

“МАХИМПЭКС” ХК-ИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Илтгэгч: Ж.Чинзориг “Мах Импэкс”
ХК-ийн ТУЗ-ийн дарга

2020 оны 04 дүгээр сарын 26

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, урилгаар оролцож байгаа эрхэм хүндэт зочидта бүхэнд энэ одрийн мэндийг Мах Импэкс ХК-ийн нийт ажилтан, ажилчдын өмнөөс болон хувиасаа хүргэж байгааг хүлээн авна уу.

Махимпэкс ХК-ийн ТУЗ-өөс 2019 онд хийсэн ажлын тайлангаа та бүхэнд танилцуулан хэлэлцүүлж та бүхний гаргасан үнэтэй санал санаачилга, шүүмжлэлийг 2020 оныхоо ажилд тусган хэрэгжүүлэх болно.

Өнгөрсөн онд тайлангийн хурлаар тавьсан зорилтуудыг ханган биелүүлэх зорилгоор бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа хийж компанийн хэмжээнд бизнес төлөвлөгөө, техник зохион байгуулалтын төлөвлөгөө гарган ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөн ажиллаа.

Бид МУ-ын Засгийн газар, Хүнс хөдөө аж ахуйн салбараас гаргасан бодлого, хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрийн үйл ажиллагааг нийцүүлэн салбартаа тэргүүлэх чиглэлийг баримтлан ажиллаж ирлээ. Манай улс нь хүн амын дотоодын махны хэрэгцээгээ бүрэн хангаад зогсохгүй цаашид жил бүр 9 сая толгой мал буюу 180 гаруй мянган тонн мах экспортлох боломжит нөөц бий гэсэн судалгаа байдаг. Тайлант онд ИБНИУ-д 703 тн хонины ангилсан мах, БНХАУ-д 3875 тн адууны шулсан махыг тус тус өөрийн үйлдвэрт бэлтгэн экспортолсон.

Экспортод чиглэсэн бодлого, үйл ажиллагаанаас гадна дотоодын махны хангамжийг тогтворжуулахаар Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас гаргасан бодлого шийдвэрийг дэмжин ажиллаж нийслэл хотын хүн амын 2020 оны хаврын улирлын махны хэрэгцээнд зориулан 1000 гаруй тонн мах нөөцлөөд байна.

Энэ бүхэн нь Малын генетик нөөцийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг хэрэгжүүлж, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 06-ны 42 дугаар тогтоолоор батлагдсан "Гурван тулгуурт хөгжлийн бодлого"-д хөдөө аж ахуйн салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх, эрүүл аюулгүй, шим тэжээллэг хүнсээр иргэдээ хангах, хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрлэлийг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх, улмаар хүнс экспортлогч орон болох зорилтыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулан эрчимтэй ажиллаж байгаагийн үр дүн юм.

НЭГ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд зохион байгуулж байгаа томоохон хөтөлбөрүүдийн нэг болох 2016онд эхэлсэн “Малчдыг дэмжих хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн тайлант онд хөдөө орон нутагт баг томилон ажиллуулах, малчдын малыг газар дээр нь очиж зөөвөрлөх ажлуудыг зохион байгуулж нийт 3,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хийж 25000 толгой хонь, 7250 толгой ямаа, 1000 орчим толгой үхрийг малчдын гар дээрээс худалдан авч үйлдвэрлэлийн хэрэгцээнд нийлүүлсэн байна.

Мөн Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор баталсан “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”-ын заалт, Засгийн газрын мөн оны 23, 26 дугаар тэмдэглэлийн хүнсний хангамж, үнийн түвшинг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд Нийслэлийн хүн амын хэрэгцээнд 2019-2020 онд худалдан борлуулахаар нийт 500 тн хонь, 300 тн ямаа, 200 тн үхрийн мах нөөцөнд бэлтгээд байна.

Тайлант онд компанийн техник тоног төхөөрөмж, барилга байгууламжийг үйлдвэрлэлийн чанар, шаардлагад нийцүүлэх, дулаан, эрчим хүчний алдагдалыг багасгах зорилгоор төлөвлөгөө гарган ажиллаж дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Бод мал төхөөрөх цехийн 1152 м² шал мозайкдах
- Эхлэн боловсруулах үйлдвэрийн барилгын 1296 м² талбайд дулаалга хийх, цонх солих ажил
- Дотор эрхтэн, дайвар бүтээгдэхүүн боловсруулах цехийн барилгын дотоол засварыг иж бүрэн засаж дуусгалаа.
- Эхлэн боловсруулах цехийн шатны хонгилын засвар, 172 м² талбайд тус тус барилга засварын ажил хийсэн.

Техник тоног төхөөрөмж шинэчлэлийн ажлын хүрээнд нийт 82,7 сая төгрөг төлөвлөн ажиллаж, төлөвлөгөөний дагуу цаг хугацаандаа чанартай хийж дуусгалаа. Үүнд:

- Дотор эрхтэн, дайвар бүтээгдэхүүн боловсруулах цехийн халуун хүйтэн усны шугам, коллекторыг иж бүрэн шинэчлэх ажил.
- Бод, бог мал төхөөрөх цехүүдийн халуун хүйтэн усны шугамын шинэчлэлийн ажлыг хийж дуусгасан.
- Бод мал төхөөрөх, дотор эрхтэн боловсруулах цехүүдийн гэрэлтүүлэг, цахилгааны шитүүдийг солих ажил.
- Мал төхөөрөхөд ашигласан хутгыг 82-оос дээш хэмтэй халуун усаар ариутгах шаардлагад хийцүүлэн 22 ширхэг хутга ариутгагчийг шинээр хийсэн.
- 1968 онд ашигалалтад орсон бод малын арьс хуулах машиныг орчин үеийн хүнсний шаардлагад тохируулан өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан шинээр хийсэн.
- Бод мал төхөөрөх, дайвар бүтээгдэхүүн, дотор мах боловсруулах цехүүдийн вандан тавиурыг шинээр хийж, цусалгааны хэсэг болон дотор эрхтэн дамжуулах хоолой, ширээ, чануудыг технологийн чанар стандартад тохируулан зэвэрдэггүй гангаар хийсэн.

ХХААХҮЯ-наас төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, олон улсын төслүүдтэй хамтран зохион байгуулж "Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээ, мөшгих тогтолцооны загвар арга хэмжээ"-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд дотоодын зах зээлд худалдаалах мах махан бүтээгдэхүүний гарал үүслийг бүртгэлжүүлэх иж бүрэн багаж тоног төхөөрөмжийг суурилуулсан. Малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн эргэн мөшгих тогтолцооны ачаар, хэрэглэгч ухаалаг гар утасны "Мал эмнэлгийн гэрчилгээний систем аппликэйшн"-ыг ашиглан тухайн махан бүтээгдэхүүн дээрх зураасан кодыг уншуулахад аль аймаг, сумаас бэлтгэсэн мах болохыг, тухайн малыг ямар мал эмнэлэг хариуцаж байсныг, аль үйлдвэрт, хэзээ төхөөрснийг мэдэх боломжтой болж байгаа юм.

Мэргэжилтнүүдийн мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх орчин үеийн техник технологитой танилцуулахаар махны үйлдвэрүүдийн тоног төхөөрөмж технологийн дэлхийн чиг хандлагыг тодорхойлдог гурван жилд нэг удаа ХБНГУ-ын Франкфурт хотод зохиогддог Олон улсын нэр хүндтэй IFFA үзэсгэлэнд оролцсон. Бог малын толгойг хуйхлан шулж, вакуумдан савлаж худалдаанд гаргах, малын бүх төрлийн дотор эрхтэнийг жижиглэн савлаж худалдаанд гаргах, сав баглаа боодлыг шинэчлэн шинэ шатанд гаргах зорилтыг хэрэгжүүлэхээр энэхүү үзэсгэлэн яармагаас Итали улсад үйлдвэрлэсэн skin packaging машиныг худалдан авсан.



Skin packaging машин нь хүнсний бүтээгдэхүүнийг бүх гадаргуу дээр битүүмжлэхэд зориулагдсан хэлбэрийг нь хадгалдаг сав баглаа боодлын хамгийн сүүлийн үеийн дэвшилтэд технологиор савладаг юм.

Үйлдвэрийн мэргэжлийн онцлогоос шалтгаалж Хужирт рашаан сувилалд 11 хүн амрааснаас тус компанид олон жил үр бүтээлтэй ажилласан өндөр настан 2 хүн амарчээ. Үйлдвэрчний эвлэлийн хороо нь Итгэлт хамбын аялалд 4 хүн амраасан. Мөн өрх толгойлсон, амьжиргааны түвшин доогуур 3-н өрхөд түлээ нүүрсний мөнгө олгосон. Үр бүтээлтэй ажилласан ажилтан ажилтнуудаа урамшуулах зорилгоор 14 ажилтаныг БНХАУ-ын Бээжин хотод аялуулсан.

Тайлант онд тус компанид олон жил үр бүтээлтэй ажилласан ажилтнуудаас Төрийн дээд одон медаль Алтан гадас одонгоор 4 ажилтан, Хөдөлмөрийн хүндэт медалиар 7 ажилтан үүнээс өндөр настан 2 хүн, салбарын тэргүүний ажилтан цол тэмдэгээр 10 ажилтан тус тус шагнагдсан.

ХОЁР. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Компанийн 2019 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг 2018 оны үзүүлэлттэй харьцуулсан шинжилгээг хүргэж байна. Тус компани нь 2019 онд 140 гаруй ажилтантайгаар 10 гаруй нэр төрлийн мах, махан бүтээгдэхүүн, 20 гаруй нэр төрлийн дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулалт хийсэн.

Тайлант онд компанийн нийт хөрөнгө 37 хувиар буюу 15.4 тэр бум төгрөгт хүрч өссөний 85.1 хувь нь эргэлтийн хөрөнгө эзэлж байна. Энэ нь компанийн хөрөнгө оруулалт нэмэгдэж ашигт ажиллагааг дээшлүүлэх суурь болж өгч байна.

2019 онд 819.3 саятөгрөгийнцэвэршигтайажилласнаарцэвэршигийг40.8 саятөгрөг буюу өмнөх оноос 6 хувиар өсгөсөн байна.

(сая.төг-өөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	2018 он	2019 он	өөрчлөлт	хувиар
1	Эргэлтийнхөрөнгө	8,938.90	13,185.00	4,246.10	48%
2	Эргэлтийнбусхөрөнгө	2,363.20	2,307.70	(55.50)	-2%
3	Нийтхөрөнгө	11,302.10	15,492.70	4,190.60	37%



Эх үүсвэр

(сая.төг-өөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	2018	2019 он	өөрчлөлт	хувиар
1	Өртөлбөр	8,322.70	12,150.10	3,827.40	46%
2	Эздийнөмч	2,979.40	3,342.60	363.20	12%
3	Нийтөрбаээздийнөмч	11,302.10	15,492.70	4,190.60	37%





Борлуулалт үр дүн

№	Борлуулалтын төрөл	х/н	борлуулалтын	
			Үнийндүн /сая.төг/	эзлэхувь
1	БНХАУ- д экспортын борлуулалт	тн	18,393.00	45%
2	ИБНИУ д экспортын борлуулалт	тн	6,969.20	17%
3	Дотоодын махны борлуулалт	тн	15,650.50	38%
	ДҮН		41,012.70	100%



№	Үзүүлэлт	2018 он	2019 он	өөрчлөлт	хувиар
1	Нийторлого	41,667.4	44,095.8	2,428.40	6%
2	Нийт зардал	40,888.8	43,276.3	2,387.55	6%
3	Цэвэр ашиг	778.7	819.5	40.85	5%

Ашигт ажиллагааны шинжилгээ



ГУРАВ. КОМПАНИЙН ЦААШДЫН ЗОРИЛТ

Үйлдвэрлэлийг хөгжүүлж хүчин чадлыг нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, аюулгүй мах, махан бүтээгдэхүүнээр хангах боломжийг сайжруулах, гадаад экспортыг нэмэгдүүлэхийн тулд дараах ажлуудыг гол зорилт болгон ажиллана. Үүнд:

- НАССР тогтолцооны угтвар нөхцлийг сайжруулах ажлын хүрээнд хуучин бод богийн өлөнгийн цехийг ажилчдын цайны газар, үйлчилгээний зориулалтаар шинэчлэн засварлах зураг төслийг технологийн урсгалд нийцүүлэн боловсруулах
- Боловсруулсан зураг төслийн дагуу барилгын засварын ажлыг хийж, цахилгаан, сантехникийн шугам, цайны газар үйлчилгээний үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэн тохижуулах.
- Мал эмнэлэгийн лабораторийг шинэчлэн тохижуулж мал төхөөрөхөөс эцсийн хэрэглэгчид хүрэх хүртэл бүх шат дамжлага хяналттай болгох, бүтээгдэхүүний гарал үүслийг бүртгэлжүүлэх, мөшгих тогтолцоог улам боловсронгуй болгоно.
- Хөргөлтийн системийн найдвартай ажиллагааг хангахад аммиакны насос, ус хөргөх төхөөрөмж, конденсаторийн усны насосуудыг шинээр худалдан авч суурилуулах.
- Эрчим хүч хэмнэх, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн хувьд хүйтэн усны насосонд давтамж хувиргагч тавих, уурын конденсатыг засварлаж эргүүлэн ашиглах ажлуудыг үргэлжлүүлэн хийж хэрэгжүүлэх ажлыг хийхээр төлөвлөөд байна.
- Мах хадгалах зоориудын хаалгыг шинэчлэх ажлыг хийх, ингэснээр хөргөлтийн алдагдлыг багасгаж эрчим хүчний хэрэглээг тодорхой хэмжээнд бууруулах юм.
- Малын бүх төрлийн дотор эрхтэнийг жижиглэн савлаж худалдаанд гаргах, сав баглаа боодлыг шинэчлэн шинэ шатанд гаргах зорилт тавьж байна.

- Толгой хуйхлах цехийг шинэчлэн тохижуулж, тоног төхөөрөмжийг байршуулах, бог малын толгойг хуйхлан шулж, вакуумдан савлаж худалдаанд гаргах ажлыг зохион байгуулна.
- Экспортыг нэмэгдүүлж ИБНИУ-д хонины ангилж шулсан мах 1000 тн, БНХАУ-д адууны шулсан мах 2000 тн-ыг бэлтгэн нийлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
- Ажилтан албан хаагчдыг ээлж дараатайгаар мэргэшүүлэх сургалтад тогтмол хамруулах замаар боловсролын түвшинг байнга ахиулан ажиллах. Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд төлөвлөгөөт ажлуудыг тогтмол хийнэ.
- Мэргэжилтнүүдийн мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх орчин үеийн техник технологитой танилцуулахаар олон улсаас зохион байгуулагдаж буй үзэсгэлэн яармагт оролцоно.

Хувьцаа эзэмшигч та бүхэн Махмпэкс ХК-ийн 2019 оны үйл ажиллагаа, цаашид тавих зорилтод үнэтэй санал гаргана гэдэгт итгэж байна.

Та бүхэнд ажил хөдөлмөрийн амжилт эрүүл энх сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА